

## АВИА, АВИАЛБАРЫН УТГА БА ХҮНИЙ АНХНЫ ХЭЛ

Г. Буянтогтох\*

Хэлбичгийн ухааны судлууштай сонин асуудлын нэг бол хүн төрөлхтний анхны хэл, түүний хөгжил хувьслын түүх юм. Өөрөөр хэлбэл, хүн анх ямар хэлтэй байв? Тэр хэл одоо байна уу, устсан уу? Байгаа бол хаана байна вэ? гэх мэт олон асуулт хариу нэхэж байна. Энэ тухайд, “*Аль эрт устаж үгүй болсон анхны хүй нэгдлийн нийгмийн хэлний шинжийг баттай хэлэх чадвар орчин үеийн хэлшинжлэлд алга байна*” (Мөөмөө.1996. х - 37)<sup>1</sup> хэмээх үзэл бодол нэлээд газар авч, батжин бэхжисний дээр “. . . авианд ямар нэг төрөлхийн утга байхгүй. . . авиалбар тустаа байхдаа ямар ч утгагүй юм” (Эйчисон. 2002. х – 52-53)<sup>2</sup> гэсэн дүгнэлт үеэс үед дамжсаар баттай итгэл үнэмшил болон тогтжээ.

Гэтэл, хүн төрөлхтөн эрт балар цагт анх хэлтэй болохдоо салангид авиаг цувруулан дуудаж (Мөөмөө.1996.х.39)<sup>3</sup>, түүгээр санаа бодлоо тоймын төдий илэрхийлэн харилцаж явсаар, амьдрал тэмцлийн дунд ертөнцийг бага багаар танин мэдэж, тэр чинээгээр байгалийн амьтнаас алхам алхмаар холдон, жинхэнэ нийгмийн амьтан-хүн болж төлөвшсөн бөгөөд хүний хөгжлийн энэ замын гэрч баримт нь түүний хэл сэтгэхүй юм. Үүнд, анх салангид авиагаар харилцаж байсан хүн яваа яваандаа нийлмэл авиа буюу анхны үгээ дуудан харилцах болсон байна. Эртний хүний харилцааны хэрэглүүрийн үндсэн нэгж болсон тэр анхны үгс голдуу авиа болон авиа дуурайх, дүрслэх үгс байсан нь гарцаагүй. Үүнийг хэлд орж буй хүүхдийн нэрлэхүйгээс мэдэхэд түвэгтэй бус. Учир нь, “*Хүний хэлэхийн хөгжилд авиа дуурайх явдал чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Авиа дуурайх үгс нь юмс, үйл хөдлөлийн тухай төсөөллийг ойлгомжтой илэрхийлэн үзүүлж байжээ. Үүний жишээ нь хүүхдийн хэлэх юм. Энэ талаар Дарвины ажиглалт сонир-холтой. Түүний дөнгөж ярьж эхэлж байсан ач хүү нь галууг квак гэдэг үгээр нэрлэсэн байна. Бас усыг ч ингэж нэрлэжээ. Тэгээд энэ үгээ бүх жигүүртэн, шавж, бүх шингэн юмыг нэрлэхэд ашигласан байна. Нэг удаа тэр хүү франц зоосон дээрх бүргэдийн дүрсийг хараад энэ шинжээр бүх зоосыг квак гээж нэрлэж байжээ*” (Мөөмөө.1996.х.43)<sup>4</sup>. Хүүхдийн хэлний онолд үзэж байгаагаар, хүүхэд хэлд орж, саадгүй ярьж харилцаж сурах замдаа тухайн хэлтэн ард түмний сэтгэлгээний түүх, сэтгэхүйн замыг давтан туулж өнгөрдөг болох нь нэгэнт илэрхий

\* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

<sup>1</sup> С.Мөөмөө. *Ерөнхий хэлний шинжлэл*. УБ.1996

<sup>2</sup> Жийн Эйчисон. *Хэл шинжлэл*. УБ.2002

<sup>3</sup> С.Мөөмөө. *Ерөнхий хэлний шинжлэл*. УБ. 1996

<sup>4</sup> С.Мөөмөө. *Ерөнхий хэлний шинжлэл*. УБ. 1996

болжээ. Тийм учраас, хэлд орж эхэлж байгаа хүүхэд дээрх жишээнд байгаачлан, авиа дуурайн нэрлэх нь их байдаг. Ингэж юм үзэгдлийг авиа дуурайн нэрлэх явдал хэлд орж байгаа хүүхдээр үл хязгаарлагдана. Үл нэвтрэлцэх өөр өөр хэлтэн харилцах явцдаа бие биеийн хэлснийг буруу ухааран, шушмаа, юкатан гэх мэтээр нэрлэн хэвшүүлсэн нь цөөнгүй бий аж. Энэ нь, чухамдаа эртний хүн авиа дуудаж, авиа дуурайн нэрлэж, түүгээр харилцаж байсны жишээ баримт юм.

Гэхдээ хүн зүгээр л нэг авиагаар эхэлж харилцаагүй, түүний ухамсар сэтгэлгээнд юм, үзэгдлийн талаархи тодорхой ухагдахуун бэлэн болсон байсан бөгөөд гагцхүү түүнийг гарган хэлэх хэрэглүүр буюу өгүүлүүр сайн хөгжөөгүй байсны улмаас зөвхөн төрөл бүрийн авиа гарган харилцаж байсан гэж болно. Үүнийг хүүхэд хэлд орж байгаа явц болон хөгширч доройтсон, туйлдаж ядарсан үедээ арай ядан ярьж харилцаж байгаа байдлаас мэдэхэд түвэг орохгүй. Ташрамд дурдахад, казах хэл сэтгэлгээтэн нялх хүүхэд эхлэн ярьж сурахыг, “*Хэл нь гарах*” гэж хэлдэг нь маш оновчтой нэрлэлт байна. Товчдоо бол “... мичний хөгжсөөгүй болхи төвөнх хэрэгцээний эрхээр нэг аялгуунаас нөгөө аялгуунд аажим боловч хэлбэрэлтгүй өөрчлөгдөн боловсорч, тасралтгүй шилжин хөгжсөөр, амны хөндийн эрхтнүүд ч тус тус ялгаатай авиаг дараа дараагаар дуудаж сурчээ” (Энгельс. х -76 - 78)<sup>5</sup>.

Дурдсан бүхнээс юу гэж хэлж болохоор байна вэ? гэвэл, хүн төрөлхтний анхны хэл устан үгүй болоогүй бөгөөд тэр хэл өнөөгийн нэн хийсвэрлэн гарч ирсэн хэлтэй зэрэгцэн оршоор байна. Гагцхүү түүнийг устаж үгүй болсон мэтээр бодож, анзааралгүй явж ирсэн гэмээ хүлээж нарийвчлан судлах цаг болжээ. Өнөөгийн хэлэнд байгаа бүх авиалбар болон дуурайх үгс, мэдрэхүйн өгүүлбэр буюу бүтэц бус өгүүлбэр бол цөмөөрөө хүний анхны хэл гэж үзэж байна. Энэ хэлийг монгол хэлний авиалбарын анхны ерөнхий утгаар тоймлон жишээлэхэд:

**А эгшиг:** Орон үл харгалзан, аугаа бөгөөд чанд, хүчтэй шинж байдлаар орших, арга чанарт гэсэн үндсэн утгатай.

**Э эгшиг:** Орон үл харгалзан, зөөлөн, ээвэргүү шинж байдлаар орших, билиг чанарт гэсэн үндсэн утгатай.

**И эгшиг:** Орон үл харгалзан нарийн нягт бөгөөд явцуу чигжүү шинж байдлаар орших, билиг чанарт гэсэн үндсэн утгатай.

**О эгшиг:** Орон үл харгалзан, оорцог цомцгор шинж байдлаар орших, арга чанарт гэсэн үндсэн утгатай.

**У эгшиг:** Орон үл харгалзан, урт удаан, унжруу сунжруу шинж байдлаар орших, арга чанарт гэсэн үндсэн утгатай.

**Ө эгшиг:** Орон үл харгалзан цөмцгөр бөөний шинж байдлаар орших, билиг чанарт гэсэн үндсэн утгатай.

**Ү эгшиг:** Орон үл харгалзан, урт удаан, унжран сунжирч үргэлжлэх шинж байдлаар орших, билиг чанарт гэсэн үндсэн утгатай.

**Н гийгүүлэгч:** Нам доор, нэгдэж нийлсэн, нягт цул, газар шороо, нутаг орон гэсэн ерөнхий утгын үндэс болдог.

**Б гийгүүлэгч:** Бүтэж бий болох, орны дотор байх орших гэсэн ерөнхий утгын үндэс болдог.

**Х гийгүүлэгч:** Хол, тасархай бөгөөд онцгой оорцог, хожим гэсэн ерөнхий утгын үндэс болдог.

**Г гийгүүлэгч:** Гарах, холдох, ангиграх, тусгаарлах гэсэн ерөнхий утгын үндэс болдог.

**М гийгүүлэгч:** Б -тэй гарал нэг бөгөөд ерөнхий – тодорхойн харилцаагаар ялгарна. Өөрөөр хэлбэл, М бол Б -гээр илрэх ерөнхийн доторхи тодорхой утгын үндэс болдог. Жишээлбэл, Би хэмээх ерөнхий утгын дотор багтсан тодорхой утга бол Ми болно.

**С гийгүүлэгч:** Салах тасрах, салбарлах холдох гэсэн ерөнхий утгын үндэс болдог.

<sup>5</sup> Ф. Энгельс. *Мич хүн болоход хөдөлмөрийн гүйцэтгэсэн үүрэг*. К.Маркс. Ф. Энгельс. Түүвэр зохиол 3-р боть.

**Т (Ч) гийгүүлэгч:** Хол тэргээд, тусгаар оршин байх, хатуу чанд гэсэн ерөнхий утгын үндэс болдог.

**Д гийгүүлэгч:** Дээгүүр байх, гадарга дээр ойр орших, бүрхэн байх, эвэргүү чанарт гэсэн ерөнхий утгын үндэс болдог.

**Й (Ж) гийгүүлэгч:** Анхны байдлаас хувиран хөдөлсөн, ерийн бус шинж чанарт гэсэн ерөнхий утгын үндэс болдог.

**Р гийгүүлэгч:** Эрчимтэй хүчтэй, хатуу чанд гэсэн ерөнхий утгын үндэс тус тус болдог гэх мэт.

Ийм учраас авиалбар утгагүй гэхээ больж, дээрх мэт тойм утгыг лавшруулан нарийвчилж судлах шаардлагатай буйн дээр бүх дуурайх ба дүрслэх үг, бүх бүтэцгүй өгүүлбэр, ялангуяа мэдрэхүйн өгүүлбэрийг сайтар нягтлан шинжлэх хэрэгтэй байна. Тэгэж гэмээн муур, нохой мэт амьтны хэлийг цахим тооцоолуурын хүчээр хүний хэлнээ хөрвүүлэн буулгаж чадаад байгаа өнөө цагт хүний анхны хэл, тэр тусмаа монгол хүний анхны хэлийг багцаагаар боловч мэдэн төсөөлж чадах буй заа. Ингэж чадвал, аяндаа л, хэлний авиа(авиалбар) бол бүтээвэр зэрэг хэлний бусад нэгжийн адил утгатай, авианы тогтолцоо бол хэлний бүтцийн онцгой салбар биш, хүний анхны хэлний бие даасан тогтолцоо буюу бие даасан хэл, Авианзүй бол Хэлбичгийн ухааны доторхи онцгой байр суурьтай салбар биш, тусгаар нэгэн хэлшинжлэл буюу хүний анхны хэлийг судалдаг хэлшинжлэл гэдгийг хүлээн зөвшөөрнө.

## SUMMARY

In this brief article, author discusses about Mongolian phonemes. According to the author, the phonemes are in a sense, such as morphemes, words and sentences. They are the first ancestral language or ancient speech.